

ГАДААД, ДОТООД МОНГОЛ ГЭДЭГ НЭРИЙН ҮҮСЭН УЛИРСАН АСУУДАЛД

Ли Бао Вэн [China]

Бээжин дэхь Үндэсний түүхийн нэгдүгээр архив

Өгүүллийн товч утга: Дайчин улсын үеийн архивын баримт хэрэглэгдэхүүнд тулгуурлан Монголын түүхийн судалгаан дахь “Гадаад Монгол”, “Дотоод Монгол”, “Гадаад засаг”, “Дотоод засаг” зэрэг нэрийдлийн үүссэн, улирсан ул мөрийг мөшгөн судалж сонирхолтой санал дүгнэлт дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: “Гадаад Монгол”, “Дотоод Монгол”, “Гадаад засаг”, “Дотоод засаг”, “Гадаад, дотоод Монголчууд”

XIX зуунаас нааш бичигдсэн Монголын түүхэнд холбогдсон ном зохиолд “Гадаад Монгол” “Дотоод Монгол” “Гадаад засаг” “Дотоод засаг” гэх зэрэг нэрсийг хутгадаг байсан болохоор, эдүгээгийн олонхи эрдэмтэд тэдгээрийн нөлөөнд автагдан, өгүүлэл илтгэлдээн өргөнөөр ашиглан, мэргэжлийн бус хүмүүсийг байтугай, зарим *iin un* ыг ялгах чадвар муутай эрдэмтдийг хүртэл толгойг нь эргүүлдэг болжээ. Өгүүлэгч би удаан жил Дайчин улсын үе дэх архивын бичиг дээр ажиллаж, “Гадаад Монгол, Дотоод Монгол” хэмээх нэрийн тухай архивын бичгүүдэд гарч байсан байдал ба энэхүү нэрийдлийн үүсэн улирсан ул мөрийг анхааралдан авч, энэ удаагийн хуралдаан дэвшүүлэн, та нарын шүүмжлэлийг хүсэж байна.

Зүрчидийн Нурхачи (nurhaci, 1559-1616-1626)-ийн “bithe-i boo” “Бичгийн өргөө” болон Хунтайж (1592-1626-1636-1643)-ийн үе дэхь “bithe-i boo” “Бичгийн өргөө” “文馆” (Манжийн хунтайжийн Сэцэн хааны гуравдугаар оноос хятадаар ингэж нэрлэх болжээ)-өөс архивласан, эрхлэн дэвтэрлэж архивласан дэвтрүүдийн манж хэл, манж үсгээр бичигдсэн «Судар дэвтэр»-т Манжийн Сэцэн хаан /Бас Тэнгэрийн Сэцэн гэдэг/-ы зургаадугаар он (1632) тавдугаар сарын шинийн зургаанаа “ice ninggun-de.....tere inenggi **tulergi monggo-i** beiise-de wasimbuha bithei gisun.han hendume.....musei juwan guisa-de wasimbuha bithei gisun.....musei juwan guisa de wasimbuha bithei gisun han hendume.....”¹³ арван наймнаа “.....juwan jakuin de dashuiwan-i ergi galai **musei monggo-i** cooha.....”¹⁴ зургаан сарын гучин “.....guisin-de.....juwan guisai baha olji niyalma.....**tulergi monggo beiise-i** baha olji ton.....**jakuin guisai ice monggo-i** taiijisa lama ukame jihe monggoso esei baha olji be ton gaihakuibi han i cooha dosika jurgan emgi dosika monggo beiise-i baha olji ton.....”¹⁵ арван сарын арван “.....han-i hesei jirhalang beiile sahaliyan beiile **tulergi dahaha monggo-i** beiise-i nuktere babe dendeme bume jorime jai doro shajin—be toktobume gisurefi jihe.....”¹⁶ арван хоёр сарын шинийн хоёрт “.....han joo bithe wasimbume hendume gurun-i **manju nikan monggo-i** gusai ejelehe amban.....”¹⁷ “.....**gurun i monggo beise-i** sargata monggo hehesi.....”¹⁸

¹³ (日译满档·太宗 p. 762, 中译满档 p. 1278)

¹⁴ (日译满档·太宗 p. 769, 中译满档 p. 1283)

¹⁵ (日译满档·太宗 p. 813, 中译满档 p. 1314)

¹⁶ (日译满档·太宗 p. 859, 中译满档 p. 1345)

¹⁷ (日译满档·太宗 p. 870, 中译满档 p. 1351)

¹⁸ (日译满档·太宗 p. 872, 中译满档 p. 1352)

хэмээн “Гадаад Монгол” гэдэг үгийг үүсгэж түүнтэй төрийн зорилгоон нэгтгэж, монгол нутагтаан аж бүхий, дайн дажинд хамтаар морьддог Монголын аймгуудыг нийтэд нь нэрийдэж эхэлсэн байдаг.

Үүнээс өмнө, Сэцэн хааны тавдугаар он (1631) гурван сарын хорин тавнаа “suire han-i sunjacī aniya.....ilan biya.....orin sunja—de.....ineku inenggi nikan—i cooha jibi **jasei tuile nukteme yabure haracin-i monggoi** haha hehe juise uiheri emu tanggu isime niyalma-be wabi uiju faiitabi gamahabi. suire han-i cooha tuicike seme donjibi olji ulha dalikaku uthai burlama genehebi.” найман сарын шинийн нэгэнд “jakun biya ice-de.....tere inenggi korcin aru jarut barin aohan naiiman karacin tumet **ba bai monggoi** cooha aсанjiha.....ice ilande emu nirui bayara sunjata ing—i sunjata uksin **monggoi** juwe gusa yoni **jasei tuilergi monggoi** cooha yoni.....” хэмээн биччихүй. Мөн шинийн нэгний энэхүү тэмдэглэлийн «газар газрын» гэдгийг өөр нэгэн дэвтэрт “jakuin biyai icede.....**golo golo monggo**—i cooha be boljofi асaha korcin aru jarut aohan naiman karacin tumet ere **jakuin golo monggo-i** yafagan moringga cooha.....”¹⁹ хэмээн “газар газрын” “муж мужийн” буюу “зам замын” гэх утга бүхий “golo golo” гэдэг үгээр биччихүй. Сэцэн хааны зургаадугаар он (1632) дөрвөн сарын арван гурван “.....amargi **ba ba i monggo gurun** i golo beiise cooha gajime асанjiifi.....”²⁰ арван зургаанаа “juwan ninggun—de.....tere cimari korcin—i tusiyetu han—i ahuita deote geren beiise jarut aohan naiman aru **golo golo i monggo**—i tanggu* beiise—be isabuha.....”²¹ хэмээн “газар” “зам” “анги”, сүүлийн үед “муж” хэмээх утга бүхий “golo” гэдэг үгээр тодотгож байжээ.

Дээр ишилсэнчлэн, “Гадаад Монгол” гэдэг нь Монгол нутгаан огоорч манжид очин нийлж, Манжийн хааны шууд захиргааг хүлээж, шинээр зохион байгуулагдсан “Улсын монгол ноёд” ба “Улсын монгол хошуу”-наасаан ялгаварлан, “jasei tulergi” “边外” хэрмийн чанадах, хэрмийн гаднах зэрэг утгаар манжийн хилийн чанд, Манжийн төртэй төрийн анд бололцсон Монгол аймгуудыг 1631 он орчмоос нэрийдэж эхэлсэн юм шиг байна.

“Гадаад дотоод Монголчууд” хэмээх нэрийдлэг, Манжийн төрийн хятад орныг эзэлсэний дараа нэр утгын хувьд угийнхаасаа ялгаагүй бөгөөд өргөнөөр хэрэглэгдэх болжээ.

Тунгалаг Огторгуй хаалганы тэргүүн зэрэг хиа Раашын Энх Амгалан(1654-1661-1722)-ын тавин зургаадугаар он (1717) арван нэгэн сарын шинийн есны өдрийн айлтгалд “.....monggo g'anjur ging folome weiilere/ eiten baiitalara bushi ciyanliyang de holbobuhangge umesi/ ujen amba-be dahame erebe tulergi golo be dasara/ jurgan +guwang shan ku de afabufi ichiyabuki **ging hecen-i jakuin/ guisai monggoso tulergi dehi uyun guisai jasak i/ monggoso nuktere bai cahar monggoso ging hecen i/p.36 lamasa tulergi lamasa bure bushi-i menggun-i uheri/ ton-be tulergi golo-be dasara jurgan +guwang shan ku-ci getukeleme/ baiicame bargiyame gaiifi/ donjibume wesimbufi g'anjur ging folome weiilere de baiitalakini/ sembi.....”²² “.....Нийслэл хотны найман хошууны Монголчууд, гадаад дөчин есөн хошууны засгийн монголчууд, нүүдэллэх газрын цахар монголчууд, Нийслэл хотын лам нар, гадаад лам нар.....” гэж тов тодорхой ялгаж бичжээ. Хэдэн жилийн дараа, сул амбан хошууны эзэн Тура нарын Энх Амгалангийн жардугаар он (1721) дөрвөн сарын шинийн дөрвөний өдрийн айлтгалд, дээр айлтгал дахь өглөг өгсөн**

¹⁹ (日译满档·太宗 p. 527, 中译满档p. 1129)

²⁰ (日译满档·太宗 p. 741, 中译满档p. 1265)

²¹ (日译满档·太宗 p. 748, 中译满档p. 1269)

²² Palace Museum Journal 2005. 5 p. 81—82.

байдлыг давтахдаан “.....ice nadan-de wesimbuhengge tura sei wesimbuhengge **dorgi tulergi monggoso lamasaci** aiisilaha bushi menggun ilan tumen emu minggan juwe tanggu* nadanju emu yan ilan jiha ilan fun ejen-i buhe bushi menggun emu tumen sunja minggan jakuinju ninggun yan sunja jiha emu fun.....” “.....Дотоод гадаад Монголчууд, лам нараас...” гэж Нийслэл хотын Найман хошууны Монголчуудаан дотоод хэмээн, гадаад дөчин есөн хошууны засгийн Монголчуудыг Гадаад гэж хоёрт хувааж биччихүй. Бас мөн айлтгалд “.....jai **tulergi adun-i monggoso dorgi jakuin guisai monggoso** benjire unde bushi emu minggan uyunju sunja yan jakuin jiha juwe fun-i menggun-be hese gaiire-be nakakini sehebe gingguleme dahafi gaiire-be nakaki sembi.....” “.....Гадаад Монголчууд, дотоод Найман хошууны Монголчууд” гэж бичсэн “Гадаад Монголчууд”-ыг “Дотоод Монгол”²³ -доон багтааж хэлсэн нь илт байна.

Учир иймд, “Гадаад Монгол”(qhadaqhadu mongqhadu, tulergi monggo), “Гадаад аймгийн Монгол улс” (qhadaqhadu aaiimaq-un mongqhadu aulus tulergi goloᠢ monggo gurun) гэдэг нэр нь Монголын Хорчин (Хорчины харъяат горлос, дөрвөд, залайд), түмэд, Халхын зүүн гарын аймаг, Халхын баруун гарын аймаг, Харчин, Зарууд (Өвөр таван отог халхын нэг), Байрин (Өвөр таван отог халхын нэг), Аохан, Найман, Ар Хорчин, Онигууд, Хишигтэн, Үзэмчин, Сөнөд, *Abag abhanar*, Дөрвөн хүүхэд, Муу мянган, Урад, Ордосыг л нэрлэдэг байсан, 1691оны Долоннуурын чуулганы дараа, халх оронд засаг өргөмжилсөнөөс халхыг бас “Гадаад Монгол”-д багтааж, өмнө нэрийдэж байсан “Гадаад Монгол”-оон “Дотоод засаг буюу Гадаад дөчин есөн хошууны засгийн Монголчууд” гэж, шинээр засаг өргөмжилсөн Халхын гурван аймгийг “Гадаад засаг” гэж төрийн байгууламж болон газар зүйн үүднээс ялгаварлажээ.

Гэтэл “Дотоод засаг” /内扎萨克/ “Гадаад засаг” /外扎萨克/ гэдэг нэрд ер нь “Монгол” гэдэг үг нэмдэггүй байсан бөгөөд нийлүүлэн нэрийдэх үед нийтэд нь “Гадаад Монгол буюу гадаад аймгийн Монгол улс” хэмээн, хэрэв заавал ялгаж бичих чухалтай гэж бодсон байвал “Дотоод засаг, гадаад засаг буюу гадаад халх” гэж нэрийддэг байжээ.

Энд халх гэдэг нэрт гадаад, дотоод гэж тодотгосоны “Гадаад халх” /外喀尔喀/ гэж нэрлэдэгийн шалтгааныг сүвэгчилэхэд, ер нь дотоод засгуудад зориулсан Манжийн хааны засаг цаазыг удаан жил мөрдөн дагаж явсан, Энх Амгалангийн гуравдугаар он (1664) Дайчин улсад дагаар орж, засаг төрийн бэйл өргөмжлөгдөөд, зарлигаар үе улиран тасралгүй залгамжлуулсан, Юань улсын Тайзу хааны үр Гомбо илдэний /gumbu ilden/ “Халхын зүүн гарын аймаг” болон Эээр засагчийн аравдугаар он (1653) Дайчин улсад дагаар орж, засаг хошой дархан чин ван өргөмжлөгдөөд, зарлигаар үе улиран тасралгүй залгамжлуулсан, Юань улсын Тайзу хааны үр Бонтар /bontar/ -ын “Халхын баруун гарын аймаг”-ыг “Дотоод халх”(dotuqadu qalq-a)²⁴ хэмээснээсээн ялгаварласан юм болов уу хэмээмээр байна.

Ер нь Дайчин улсын хунтайжийн Сэцэн хааны наймдугаар он (1634) таван сараас өмнө байгуулагдсан Монголын явдлыг мэдэгч яаман “monggo jurgan” /蒙古衙门/ -ыг Манжийн хунтайжийн “агууд найрамдах богд хаан” хэмээгдсэн дээд эрдэмтийн гуравдугаар он (1638) зургаан сард монголоор “Гадаад монголын төрийг засагч /засах/ явдлын яаман”, манжаар “tulergi goloᠢ be dasara jurgan”, хятадаар “理藩院” хэмээн тогтоосны “Гадаад Монгол” гэдэг үг нь гадаад зам(аймаг, муж) хэмээх утга бүхий манж үгийн “tulergi golo”, хятадаар 《藩》 гэсэн манж,

²³ 亦见噶勒丹qaldan p.287—289。

²⁴ 见噶勒丹qaldan p. 287—289。

монгол, хятад гурван хэлэн дэхь утга үл нийлэх үгээр нэрлэсэн бөгөөд төрийн байгууллагын нэрээр тулгуур төрөөн мөхөөсөн 1911 он хүртэл, нийт 274 жил нэрийдэн дууджай.

Мөн энэхүү яамыг Тэнгэрийг Тэтгэсэн хаан зарлиг буулгахдаан дандаа "monggo jurgan" (蒙古衙门) гэж, гадаад дотоод засгийн монгол ноёд ер нь "Их журган" (amba jurgan 大) гэж заншсан байжээ. Энэ яамаар эрхлэн тархаасан "Энх Амгалангийн зургаадугаар оны хуучин засгийн бичигт нэмж тогтоосон засгийн бичиг", Энх Амгалангийн гучин гуравдугаар онд хэвлүүлсэн 《理藩院律书qhadaqh-a-du mongqahul-un toiru-ii iasaqu iabudal-un iamun-u saqhajin-u bicig》, Тэнгэрийн тэтгэсний үе дэхь манж, монгол, хятад гурван хэлээр хэвлүүлдэг Монгол цаазны бичиг》, Сайшаалт ерөөлт, Төр гэрэлт, Бадруулт төрийн онуудад нэмэн засаж, манж, монгол, хятад гурван хэлээр удаа дараа хэд хэд хэвлүүлсэн "Зарлигаар тогтоосон гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг" зэрэг эрх зүйн бүтээлд "Дотоод засаг, гадаад засаг"-ыг хамтад нь "Гадаад Монгол" гэж тов тодорхой бичиж байгаа бөгөөд "Дайчин улсын бүгд хууль бичиг"-т ч хятад хэвлэл дэхь 外藩》 гэдэг үгийг ер нь "tulergi monggo/qhadaqadu mongqahul" гэж бичиж байдгаас Дайчин улсын төрийн түүх зохиол дахь засаг захиргааны утгаар гардаг "藩" гэдгийг гагцхүү "Гадаад дотоод засаг"-ын нийтийн нэрдэл- "Гадаад Монгол" гэж ойлгох үндэстэй мэт санагдуулж байна. Үүгээр дамжуулан Тэнгэрийн тэтгэсэн (1711-1735-1799)-ы дөчин дөрөвдүгээр он(1779)-оос туурвиж, манж монгол хятад гурван хэлээр хэвлүүлсэн "hesei toktobuha tulergi monggo hoiise aiiman-i wang gung sai iletun ulabun", 钦定外藩蒙古回部王公表传》 "Зарлигаар тогтоосон Гадаад Монгол хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шаштир"-ын монгол гарчгийг хятадаар "钦定外蒙古回部王公表传" гэж ойлгож болох бөгөөд "外藩" гэдэг нь "Хотон аймаг"-ыг тодотгож байгаагүй гэдэгт итгэж байна.

Дээр өгүүлсэнчлэн, бид архивын бичиг баримт болон Дайчин улсын хаадаас монгол нутагт зориулсан "Засаг цааз" "Хууль зүйлийн бичиг" ба төрийн суртаал болсон "Илтгэл шаштир" зэргээр дамжуулан, манж хятад орон болон монгол нутгийн хоорондох их хэрмийн умард монгол нутаг дахь засгийн эрхтэй монгол хошууд, монгол хошууны харъяат ардыг "Гадаад монгол, Гадаад аймгийн Монгол улс" буюу "Гадаад Монголчууд" хэмээн, нөгөө манж, хятад, монгол(goroki-be elhe obuha hoton Холдахиньг амаржуулагч хот, Улиастай), Уйгар Зүүнгар, (Цахар, Өөлд), Түвд орны их их хот балгасыг хадгалж суусан Найман хошуудын Монголчууд, Хөх хотын Түмэд, Цахар найман хошуу, Сүргийн хошуу, Хармөрөний жанжин яамны харъяан дахь Хөлөнбуйрын баргууд өөлд, Манжийн хааны төмөр адууг асардаг монголчууд буюу урьд цаг дахь "Улсын монголчууд"-аан "Гадаад Монгол" гэдгээр эсрэгээр "Дотоод Монгол" "Дотоод Монголчууд" гэж нэрийдэж, "Гадаад Монгол"-оон газрын байцаар "Гадаад засаг" "Дотоод засаг" гэж хоёрт ялгадаг байжээ.

Дайчин улсын архивын бичиг болон "Цаазны бичиг" "Хууль зүйлийн бичиг" дэхь нэрийдлээс гадна, "daiicing gurun i uheri kooli bithe" "大清会典" "Дайчин улсын бүгд хууль бичиг" гэдэг том бүтээл дэхь хэд хэдэн нэрийдэл, бидний өгүүлж бүхий асуудлыг тодорхойлоход төвөгшөөл учруулж, манж, хятад хоёр хэлэнд адил бус утгат үгээр бичиж, учир утгыг самууруулсан нь сонирхолтой байна. Учир иймд, юуны өмнө энэхүү бүтээлийн тухай товчхон танилцуулах чухалтай мэт санагдуулж байна.

Дайчин улсын тулгар төр байгуулагдсанаас 1911 он хүртэл нийт таван иж "会典" бүтээсэн бөгөөд, манж хятад хоёр хэлээр тус тус хэвлүүлдэг байжээ.

Анхных нь хятадаар “大清会典”, манжаараан” *daiicing gurun i uheri kooli bithe*》 хэмээн анхан нэгэн дэвтэр, бүгд зуун жаран хоёр боть, Энх Амгалангийн хорин гуравдугаар он /1684/-оос туурвиж, хорин есдүгээр он /1690/-д төгсгөжээ.

Хоёр дахь нь хятадаар “大清会典”, манжаар 《*daiicing gurun i uheri kooli bithe*》 хэмээн анхан нэгэн дэвтэр, бүгд хоёр зуун тавин боть. Найралт төвийн тавдугаар он (1727)-оос туурвиж, аравдугаар он /1732/-д төгсгөжээ.

Гуравдахь нь хятадаар “钦定大清会典” манжаар “*hesei toktobuha daiicing gurun-i uheri kooli bithe*”, хятадаар “钦定大清会典则例” манжаар “*hesei toktobuha daiicing gurun-i uheri kooli-i kooli hacin bithe*” хэмээж Тэнгэрийн Тэтгэсний арван хоёрдугаар он /1747/-оос туурвиж, хорин есдүгээр он /1764/-д төгсгөжээ. Үүнд “钦定大清会典” зуун боть, “钦定大清会典则例” зуун наян боть.

Дөрөв дэхь нь хятадаар “钦定大清会典” манжаар “*hesei toktobuha daiicing gurun-i uheri kooli bithe*”, хятадаар “钦定大清会典事例” манжаар “*hesei toktobuha daiicing gurun-i uheri kooli-i baiita hacin bithe*”, хятадаар “钦定大清会典图” хэмээн Сайшаалт ерөөлтийн зургаадугаар он /1801/-оос туурвиж, хорин гуравдугаар он (1818)-д төгсгөжээ. Үүнд, 《钦定大清会典》十函四十册. 首册含正文卷一, 合正文八十卷.

《钦定大清会典事例》七十二函三百六十册. 首四册, 正文三百五十六册九百二十卷. 《钦定大清会典图》十函四十册. 首一册, 正文三十九册一百三十二卷.

Тавдахь нь хятадаар “钦定大清会典” манжаар *hesei toktobuha daiicing gurun-i uheri kooli bithe*”, хятадаар “钦定大清会典事例” манжаар “*hesei toktobuha daiicing gurun-i uheri kooli-i baiita hacin bithe*”, хятадаар “钦定大清会典图” хэмээн Бадаргуулт төрийн арван хоёрдугаар он /1886/-оос туурвиж, хорин тавдугаар он /1899/-д төгсгөжээ. Үүнд, 《钦定大清会典》六函三十六册. 其中卷首一册, 正文三十五册一百卷.

《钦定大清会典事例》六十四函三百八十四册. 首二册八卷, 正文三百八十二册一千二百二十卷.

Тэнгэрийн Тэтгэсний арван хоёрдугаар он (1747)-оос эхлэн хорин есдүгээр он /1764/-д найруулж, дүүргэсэн 《*hesei toktobuha daiicing gurun-i uheri kooli bithe*》 《钦定大清会典》 “Зарлигаар тогтоосон Дайчин улсын бүгд хууль бичиг” (《*hesei toktobuha daiicing gurun-i uheri kooli -i kooli hacin bithe*》 《钦定大清会典则例》 “Зарлигаар тогтоосон Дайчин улсын бүгд хуулийн хууль зүйл бичиг” хэмээх манж хятад хоёр хэлээр хэвлүүлж тархаасан энэ бүтээлийн манж хэвлэлийн наядугаар дэвтэрт халхын байдлыг “*harangga aiiman-be aliha bolgobure fiyenten/ gurun-i sucungga fonde amargi ba-i monggoso kalka-i ilan han/ gemu emu erinde alban jafanjiha amala amargi babe daiilame/ toktobufi musei harangga ofi jasei tule julergi ba-i/ geren aiiman-i adali oho.....*” “.....Умард газрын Монголчууд халхын гурван хан бүгд нэгэн үед алба барьж иржээ. Хойно умард газрыг дайлан тогтоож бидний харъяат болж, хэрмийн гаднах газрын олон аймгийн адил болов.” гэж танилцуулжээ.

Мөн бүтээлийн манж хэвлэлийн далан есдүгээр дэвтэрт “*dorgi tulergi monggo hoiise aiiman-i dasan fafun-be alifi*” “Дотоод Гадаад Монгол хотон аймгийн засаг цаазыг эрхлэн” гэж бичсэнийг хятад хэвлэлд “掌内外藩蒙古回部之政令” хэмээн биччихүй. Манжаар бичсэнийг ер нь хятадаар “掌内外蒙古回部之政令” гэж бичих ёстой. Мөн манж хэвлэлд “*jasei tule julergi ba-i geren monggoso*” “Хэрмийн гаднах өмнөд газрын олон монголчууд” гэдгийг хятадаар “漠南蒙古诸部落” гэж “漠、部落” хоёр үг нэмж “*jasei tule*” хэрмийн гаднах “边外” гэдэг үгийг орхигдуулсан байна. Мөн манж хэвлэлд “*jasei tule julergi ba-i monggo-i geren aiiman*” “Хэрмийн гаднах

өмнөд газрын монголын олон аймаг” гэдгийг “漠南蒙古诸部落” гэж, “漠” гэдэг үгийг нэмж “jasei tule” хэрмийн гаднах “边外” гэдэг үгийг бас ч орхигдуулсан байна. Миний хайснаар Тэнгэрийн Тэтгэсний хятад хэвлэлд “漠南” гэдэг үгийг анх үүсгэж хэрэглэснээс биш манж хэвлэлд ерөөс ийм үг байгаагүй билээ.

Тус бүтээлийн Тэнгэрийн Тэтгэсний энэ хэвлэлд хэдийгээр ишилсэнчлэн үг үсэг хасч нэмсэн боловч архивын бичигт гардаг “Дотоод Гадаад Монгол” гэдгийн утга санааг гажуудуулаагүй гэмээр байна.

Сайшаалт Ерөөлтийн зургаадугаар он(1801)-оос туурвиж, хорин гуравдугаар он(1818)-д төгсгөсөн дөрөвдэх хэвлэл 《钦定大清会典》 манжаар 《hesei toktobuha daiicing gurun—i uheri kooli bithe》, хятадаар 《钦定大清会典事例》 манжаар 《hesei toktobuha daiicing gurun|i uheri kooli|i baiita hacin bithe》, хятадаар 《钦定大清会典图》 —аан манж хятад хоёр хэвлэлд ижлээр “amba gobi—i julerginggel|be dorgi monggo sembi” “大漠以南曰内蒙古” “Их говийн өмнөдийг Дотоод Монгол” хэмээмүй гэж угийн манж хятад орныг хэрмийн гаднах “Хөх хотын Түмэд хоёр хошуу, Цахар найман хошуу, Сүргийн хошууд, Хар мөрөний жанжин яамны харъяат Хөлөнбуйрын баргууд өөлд, Ил дэхь жанжин яамны харъяат Өөлд цахар, Түвдэд сууж хэрэг эрхлэх амбаны харъяат Дамын найман хошуу, манж хятад орны хэрмийн доторхи Дайчин улсын Найман хошууны Монголчууд” —ыг “Дотоод Монголчууд” гэж нэрийдэж байсан нэрийн утгыг нь сольсон байна. Өгүүлсэн агуулгаас нь үзэхэд энэхүү утгын “Дотоод Монгол” гэдэг нь монгол нутгийн өмнө биеэр тогтмол нутагт нүүдэллэж бүхий “Гадаад дөчин есөн засаг хошуу /Дотоод засаг/” —ыг л хэлдэг байна.

Мөн бүтээлд, “amba gobi|be dabahanggel|be tulergi monggo kalka sembi” “逾大漠曰外蒙古喀尔喀, 部四附以二(额鲁特部二旗、辉特部一旗)”, “Их говийг давсаныг гадаад Монгол халх хэмээмүй” гэж, өгүүлсэн агуулгаас нь үзэхэд угийн Гадаад Монгол хэмээн нэрдэж байсан “Дотоод, Гадаад засаг”-ын “Гадаад засаг-халх дөрвөн аймаг болон Сайн ноён аймагт хавсаргасан Өөлд аймгийн хоёр хошуу, Засагт хан аймагт хавсаргасан Хойд аймгийн нэгэн хошуу”-г л хэлдэг болжээ.

Үүнийг Бадаргуулт төрийн арван хоёрдугаар он(1886)-д төгсгөсөн мөнхүү бүтээлийн манж хятад тавдахь хэвлэлдээн уламлан мөрджээ.

Яг энэхүү үүдэлтээр, Гадаад Монголын “Дотоод засаг” “内扎萨克”-ийг “Дотоод Монгол”, “Гадаад засаг” “外扎萨克”-ийг “Гадаад Монгол” гэж угийн нэрийдэж байсан “Дотоод Гадаад Монгол” гэдэгтэйгээр нэр утгыг давхцуулсан байна. Мөн шалтгаанаас болж түүхэн дэхь хятад эрдэмтэд түүх зохиолдоон дандаа “外蒙古”(qadaqadu mongqul), гэж монгол нутгийн умард хэсгийг, “内蒙古” гэж монгол нутгийн өмнөд хэсгийг нэрлэх болжээ. Хятад гаралтай ноён түшмэл, эрдэмтэн мэргэд хааны архив дахь бичиг баримтыг олж харах боломж муутай болохоор гагцхүү тус бүтээлээр дамжиж монгол нутгийн хүн байгалийг ойлгож, чинагшид ном зохиол бичиж ухуулгын үйлдэл үзүүлэн, энэ ухуулгын нөлөөнөөс болж, дэлхий нийтээр тэгж нэрийдэх болсон байдалтай байна.

Дээр өгүүлсэнчлэн, Дайчин улсын үе дэхь “Гадаад монгол, Дотоод Монгол” гэдэг нэрийдэл нь адил бусын хоёр утгыг агуулсан ухагдахуун хэмээн дүгнэмээр байна.

Нэгд: “Гадаад Монгол” гэдэг нь манж хятад орны хэрмийн гаднах “Дотоод засаг” “Гадаад засаг-халх дөрвөн аймаг” зэргийг багтаасан өөрсдийн бага төртэй засгийн эрхт Монгол нутгийг засаг захиргааны утгаас үүсгэсэн гэж үзэлтэй. Үүний эсрэгээр засгийн эрхгүй, манж хятад орны хэрмийн гаднах Хөх хотын Түмэд хоёр хошуу, Цахар найман хошуу, Сүргийн хошууд, Хар мөрөний жанжин яамны харъяат Хөлөнбуйрын баргууд өөлд, Ил дэхь жанжин яамны харъяат өөлд цахар,

Түвдэд сууж хэрэг эрхлэх амбаны харъяат дамын Найман хошуу, манж хятад орны хэрмийн доторхи Дайчин улсын Найман хошууны Монголчуудыг “Дотоод Монголчууд” хэмээн ялгаварладаг бөгөөд “Гадаад Монгол, Дотоод Монгол” гэдэг нь Гадаад Монголчууд, Дотоод Монголчууд гэж ам өрхийн харъяалалын утгаар ч хэрэглэгдэж байжээ.

Хоёрт: Сайшаалт Ерөөлтийн онуудаас нааш говийн умардын монгол нутгийг “Гадаад Монгол” говийн өмнөдийн монгол нутгийг “Дотоод Монгол” гэж нэрлэсэн нь газар зүй болон засаг захиргааны хоёр утгыг хутгалдуулж, “Гадаад засаг Монгол, Дотоод засаг Монгол” –ын товчилсон дуудлага гэж жишиж байна.

Нөгөө Гадаад засгийн ёсоор аж төрөх Хөхнуурын Монгол, баруун замын Өөлд /Хошууд/, Эзнээ торгууд, Илийн дөрвөн замын олон аймаг зэргийг түрүү яриад байсан Гадаад Монгол “外藩蒙古” –д багтаасан боловч, эдгээр аймгууд дотоод засаг, гадаад засгаасаан засаг явуулах эрхийн талаар илүү чөлөөтэй байсан байна. Хоёрдахь утгаар өгүүлсэн “Гадаад Монгол” “Дотоод Монгол” гэдэг ухагдахуун нь 17 дугаар зуунаас нааш Хянган нурууны газрын байцыг үндэслэн, Монголчууд өөрсдөөн ар(North) өвөр /өлгө/(South) гэж тэтгэж явсан нэрээс өөрөөр, 19 дүгээр зуунаас нааш Дайчин улсын хааны харц буюу бодлогоос монгол нутаг, Монголчуудыг захирах буюу монгол нутгийн газар зүй, хүн байгалийг ойлгохдоон зориулж дуудсан нэр бөгөөд “Гадаад засаг /Монгол/” “Дотоод засаг /Монгол/” гэдгийн товчилсон нэрийдлэг гэж ойлгож байна. Энэ нь яваандаан Монголчуудын өөр зуураан газар зүйн байршлаас “ар өвөр” гэж ялгасантай ихэвчлэн нийцэх болсноос “Дотоод гадаад 内外”, “Өвөр ар 南北” гэдэг нь монголоор “өвөр ар” дээр тогтшиж, хятадаар “内外” гэдгээр хэвшиж, “dorgi tulergi monggo” “Гадаад Дотоод Монгол” гэдэг манж, монгол нэрийдэл нь Манжийн төрийн мөхлийг дагалдан түүх болон хоцорсон байна. Гэтэл бид бүхний мэдээжээр 1925 оны 10 сард, Цахар онц орны төв-Чуулалт хаалга /张家口/ -д хуралдуулж байгуулагдсан Монголоор “Дотоод Монголын ардын хувьсгалт нам”, хятадаар “内蒙古人民革命党” гэж байгааг “Өвөр монголын ардын хувьсгалт нам” гэж ойлгож болох эсэхийг одоохондоо хариу өгч чадахгүй байна. Зохион байгуулагчид болон гишүүдийн нутаг усны гарлыг үзэхэд, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн чанад дахь Шинжааны Монголчууд болон Зөвлөлтийн буриад нутгийг үл багтаасан, засагтай /аймаг хошууд /, засаггүй /Цахар, Sui Yuwan, Re He гурван онц орон, Хөлөнбуйр, Бээжин/ Монголчуудаар бүрэлдсэн бөгөөд холбогдсон орнуудаар үйл ажиллагаагаан явуулж байсан болохоор Өвөр Монгол болон Дотоод Монголыг хослуулсан нэрийдлэг болов уу гэж санагдуулж байна.

Abstract: In this article, the author discussed a misunderstanding on concepts of “outer” and “inner” Mongolia as long as some researchers made mistakes. The author found documents which hold informations of causes and meaning of those names from archives of DaiQing dynasty.

Ном зүй

1. [Дайчин улс] “a*ngge aamuqulangi un iirquduqhar aon u qaqhucin iasaq un bicig dur nemeju toqdaqhaqsan iasaq un bicig” (《康熙六年增订旧扎撒书》), 中国第一历史档案藏本.
笔者的中文译文以《康熙六年〈蒙古律书〉》为名, 刊载于《历史档案》2002年第4期, Бээжин.
2. [Дайчн улс] 《qhadaqh`a`du mongqul`un toiru`ii iasaqu iabudal`un iamun`u caqhajin`u bicig》Энх Амгалангийн гучин гуравдугаар он /1694/ы хэвлэл. 《理藩院律书》康熙三十三年刻本, Монгол улсын Үндэсний номын сан
笔者所译中文本以《理藩院律书》为名, 连同蒙古文原文誊写文本刊载于《故宫学刊》2004年总第一辑, 紫禁城出版社, 2005年, Бээжин.
 - a. 达力扎布先生的中文译文、转写文本, 连同论文刊载于中央民族大学历史系主办的《民族史研究》第五辑, 《康熙三十五年〈蒙古律例〉研究》(民族出版社, 2004年, 北京.) 与笔者所译中文本, 在对原文的理解、汉文表述与用词方面差别甚大, 不得不读.
 - b. [Орос улс] С.Д. ДЫЛЫКОВА 《ЦААДЖИН БИЧИГ》(ISBN 5-02-017993-0) 1998 он. Москва.

3. [Монгол улс] Bayarsaikhan [Монгол цаазны бичиг] (ISBN 99929-0-220-5) 2004 он Улаанбаатар [Баярсайхан гуайн энэ бүтээл дэхь "Монгол цаазны бичиг" ийн "Нэгдүгээрээс есдүгээр дэвтэр" нь Тэнгэрийн Тэтгэсний тавин дөрөвдүгээр оны хэвлэл болох бөгөөд "Аравдугаар дэвтрээс арван хоёрдугаар дэвтэр" нь Тэнгэрийн Тэтгэсний гучин нэгдүгээр оны хэвлэл болох юм. Зохиогчоос анзаараагүйгээс болсон юмуудаа, хорин гурван жил алсалсан хоёр цаг үед холбогдсон хэвлэлийг нийлүүлэн нэг иж болгож эх бичгийн судалгаа зэрэг олон ажил хийж хэвлүүлсэн бөгөөд мөн бүтээлийн эх бичгийн гэрэл зурагт тавдугаар дэвтрийн "辰" 十三 дугаар нүүрийн [02.30b] (p.129) ийг орхигдуулж, "辰" 十四 дүгээр нүүрийн [02.31a] (p.131) ийг давтуулсан байна.
4. [Дайчин улс] 《蒙古律例》载中国边疆史地资料丛刊综合卷《蒙古律例. 回疆则例》全国图书馆文献缩微复制中心, 1988年, Бээжин.
5. [Дайчин улс] 《钦定理藩院则例》《hesei toktobuha tulergi golo be dasara jurgan i kooli hacin i bithe》《iarliq iiar toqtaqaqsan qhadaqhadu mongghul un toiru ii iasaqu iabudal un iamun u qauli iuili un bicig》, Дайчин улсын үе дэхь хятад, монгол, манж хэвлэлүүд. Бээжин дэхь хааны ордны номын сан.
6. [Дайчин улс] 《钦定外藩蒙古回部王公表传》《hesei toktobuha tulergi monggo hoiise aiiman i wang gung sai ileton ulabun i iarliq iiar toqtaqaqsan qhadaqhadu mongghul qotong aaiimaq-un wang gung ut un ailetgel shastir》 Дайчин улсын үе дэхь хятад, монгол, манж хэвлэлүүд. Бээжин дэхь хааны ордны номын сан.
7. [Дайчин улс] 《大清会典》, 《daiicing gurun i uheri kooli bithe》 (满、汉单行本) 十函八十册, 首一册, 正文七十九册一百六十二卷. 康熙二十三年(1684)五月十二日始修. 二十九年(1690)四月二十六日告成. Бээжин дэхь хааны ордны номын сан.
8. [Дайчин улс] 《大清会典》《daiicing gurun i uheri kooli bithe》(满、汉单行本) 全书十四函一百册, 首一册, 正文九十九册二百五十卷. 雍正五年(1727)始修, 十年(1732)告成. Бээжин дэхь хааны ордны номын сан.
9. [Дайчин улс] 《钦定大清会典》《hesei toktobuha daiicing gurun i uheri kooli bithe》. 《钦定大清会典则例》《hesei toktobuha daiicing gurun i uheri kooli i kooli hacin bithe》(满、汉单行本) 乾隆十二年(1747), 二十九年(1764)告成. 《钦定大清会典》正文一百卷. 《钦定大清会典则例》正文一百八十卷. Бээжин дэхь хааны ордны номын сан.
10. [Дайчин улс] 《钦定大清会典》《hesei toktobuha daiicing gurun i uheri kooli bithe》. 《钦定大清会典事例》《hesei toktobuha daiicing gurun i uheri kooli i baiita hacin bithe》《钦定大清会典图》(满、汉单行本) 嘉庆六年(1801)始修, 二十三年(1818)告成. 《钦定大清会典》十函四十册. 首册含正文卷一, 合正文八十卷. 《钦定大清会典事例》七十二函三百六十册. 首四册, 正文三百五十六册九百二十卷. 《钦定大清会典图》十函四十册. 首一册, 正文三十九册一百三十二卷. Бээжин дэхь хааны ордны номын сан.
11. [Дайчин улс] 《钦定大清会典》《hesei toktobuha daiicing gurun i uheri kooli bithe》《钦定大清会典事例》《hesei toktobuha daiicing gurun i uheri kooli i baiita hacin bithe》《钦定大清会典图》(满、汉单行本) 光绪十二年(1886)始修, 二十五年(1899)告成. 《钦定大清会典》六函三十六册. 卷首一册, 正文三十五册一百卷. 《钦定大清会典事例》六十四函三百八十四册. 首二册八卷, 正文三百八十二册一千二百二十卷. 《钦定大清会典图》十二函七十三册. 首一册卷首一, 正文七十二册二百七十卷. Бээжин дэхь хааны ордны номын сан.
12. [Дайчин улс] 魏源著《圣武记》(上下) 中华书局 1984年, Бээжин.
13. [Дайчин улс] 祁韵士著《皇朝藩部要略》全国图书馆文献缩微复制中心, 1993年, Бээжин.
14. [Дайчин улс] 张穆著《蒙古游牧记》山西人民出版社 1991年, Тайюань.
15. [Япон улс] 满文老档研究会译注《满文老档》东洋文库 1955-1963年, Токио. (日译满档)
16. 《旧满洲档》(全十册) 台湾故宫博物院 1969年, Тайбэй.
17. 中国第一历史档案馆 中国社会科学院历史研究所 译注《满文老档》(上下) 中华书局 1990年, Бээжин (中译满档)
18. [Дайчин улс] Galdan a*rdeni iin a*rigel aoibur mongghul un aarat un geblei un qorii al goiqeqoda, 1999 оон. Хөх хот. (Галдан)
19. Үндэстний түүхийн нэгдүгээр архив 《Арван долоодугаар зууны өмнө хагаст холбогдох монгол үсгийн бичиг дэвтэр (1600-1650)》Өвөр монголын Багачууд хүүхдийн хэвлэлийн хороо, 1997年, Тунляо.